

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИ, АВТО ЗАСВАР ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ИВАНЫ ХУЛАНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
ДЗДҮАХ-ийн зорилт 1.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. “Үйлдвэрлэл, авто засвартай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийн хангуулах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 1.1. Авто үйлчилгээ болон үйлдвэрлэл эрхлэгчдэд салбарын хууль тогтоомж, стандартыг сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 97 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.	1-ээс доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	01	12
2.	Арга хэмжээ 1.2. Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, судалж, шийдвэрлэлтийн хариуг тухай бүр өгч, бизнесийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Ирсэн хүсэлтийн шийдвэрлэлт ийн хувь	Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2024 онд авто үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 30 иргэн, аж ахуйн нэгж хүсэлтийг шийдвэрлэсэн.	Хагас жилийн байдлаар ирсэн нийт хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна.	2025 оны жилийн эцсийн байдлаар ирсэн нийт хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна.	01	12
3.	Арга хэмжээ 1.3. Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан,	Хяналт, шалгалт зохион байгуулсан тоо,	2024 онд мэргэжлийн байгууллагуудтай хамтран 1 удаагийн хяналт	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран 1-ээс доошгүй хяналт, шалгалтын	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2-оос доошгүй хяналт, шалгалтын	01	12

	мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	шалгалт зохион байгуулж, 144 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.	ажлыг зохион байгуулсан байна.	ажлыг зохион байгуулсан байна.		
4.	Арга хэмжээ 1.4. Дүүргийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид саарал ус ашиглах, дэвшилтэт техник тоног төхөөрөмж нэвтрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Саарал ус ашигласан авто угаалгын газрын тоо	2024 онд 12 авто угаалгын газар саарал усны төхөөрөмжийг нэвтрүүлсэн.	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.	5-аас доошгүй авто угаалгын газар саарал усны хэрэглээг нэвтрүүлсэн байна.	01	12

ДЗДҮАХ-ийн зорилт 2.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.

Зорилт 2. “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд

1.	Арга хэмжээ 2.1. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор дотоод болон олон улсын үзэсгэлэн худалдаанд хамруулж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 187 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч хамрагдсан	3-аас доошгүй удаагийн өртгөтгөсөн худалдаа зохион байгуулж, 30-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилласан байна.	5-аас доошгүй удаагийн өртгөтгөсөн худалдаа зохион байгуулж, 50-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилласан байна.	01	12
2	Арга хэмжээ 2.2. “Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг байгуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Борлуулалтын төвийн байршлыг судалж, төсөл боловсруулсан байна.	Борлуулалтын төвийн байршил, төсвийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.	02	12
3	Арга хэмжээ 2.3. Өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж ажиллана.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэний тоо	-	1-ээс доошгүй удаагийн сургалтыг зохион байгуулж, 20-оос доошгүй иргэнийг хамруулсан байна.	2-оос доошгүй удаагийн сургалтыг зохион байгуулж, 40-өөс доошгүй иргэнийг хамруулсан байна.	01	12

ДЗДҮАХ-ийн зорилт 2.4 Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ.

Зорилт 3. “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах” зорилтын хүрээнд

1	Арга хэмжээ 3.1. Дүүргийн нутаг дэвсгэр дэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудтай хамтран спорт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэн аж ахуйн нэгжийн тоо	-	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 30-аас доошгүй иргэн аж ахуйн нэгжийг хамруулна.	-	01	06
2	Арга хэмжээ 3.2. "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	-	1-ээс доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 10-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна.	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 50-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна.	01	12
3	Арга хэмжээ 3.3. Төр, хувийн хэвшлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах ажлыг зохион байгуулна.	Дэмжин ажилласан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	-	2-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж борлуулалтыг дэмжин ажиллана.	5-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж борлуулалтыг дэмжин ажиллана.	01	12
4	Арга хэмжээ 3.4. "НЭГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ-НЭГ БҮТЭЭЛЧ АЖИЛ" арга хэмжээг зохион байгуулж, авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн гадна орчин, хаягийн байгууламжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, үнэ тарифыг үйлчлүүлэгчид ил тод байлгах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1-ээс доошгүй удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 30-аас доошгүй авто үйлчилгээ эрхлэгч хамрагдсан байна.	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 50-аас доошгүй авто үйлчилгээ эрхлэгч хамрагдсан байна.	01	12
Зорилт 4. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд							
1	Арга хэмжээ 4.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг чанд мөрдөн ажиллах, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг эмхлэн цэгцэлж, архивлах	Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	01	12

2	Арга хэмжээ 4.2. ERP, EDос системд албан бичиг, өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	ERP, EDос системд 13 албан бичиг, иргэний гаргасан 3 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.	100%	100%	01	12
3	Арга хэмжээ 4.3. Дээд газар, байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцоно.	Оролцсон арга хэмжээний тоо	-	1	2	01	12
4	Арга хэмжээ 4.4. Хариуцсан ажлын чиглэлээр хэрэгцээний судалгааг гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх, дээд шатны байгууллагыг мэдээллээр хангана.	Судалгааны тоо	-	3	3	01	12
5	Арга хэмжээ 4.5. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ баримт бичгийн 2.8.2-т харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлна.	Зөрчилгүй ажилласан эсэх	-	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилласан байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан зөрчилгүй ажилласан байна.	01	12

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо Суралцсан кредит цаг	-	1	2	01	12

2	Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж эсхүл бие даан суралцаж эзэмшинэ.	Хамрагдсан сургалтын тоо	-	1	1	01	12
---	--	--------------------------	---	---	---	----	----

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИ, АВТО
ЗАСВАР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)


..... / И.ХУЛАН/
(Нэр, гарын үсэг)


2025.01.15

(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

(Албан тушаал)


..... / Л.САРУУЛТУЯА /
(Нэр, гарын үсэг)

(Огноо)

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИ, АВТО ЗАСВАР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ИВАНЫ ХУЛАНГИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
ДЗДҮАХ-ийн зорилт 1.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. “Үйлдвэрлэл, авто засвартай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийн хангуулах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 1.1. Авто үйлчилгээ болон үйлдвэрлэл эрхлэгчдэд салбарын хууль тогтоомж, стандартыг сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 97 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд авто үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд 2 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүнд: I. “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ын талаар 1 удаагийн сургалт зохион байгуулж, 80 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан, худалдаа үйлчилгээний газруудад нийт 1870 гарын авлага боловсруулсан. II. Нийтийн тээврийн бодлогын газартай хамтран авто үйлчилгээний салбарын холбогдох хууль, тогтоомж, стандартын талаар мэдлэг олгох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж, нийт 68 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.	2025.01.02 - 2025.12.31	100%

2.	Арга хэмжээ 1.2. Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, судалж, шийдвэрлэлтийн хариуг тухай бүр өгч, бизнесийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Ирсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2024 онд авто үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 30 иргэн, аж ахуйн нэгж хүсэлтийг шийдвэрлэсэн.	2025 оны жилийн эцсийн байдлаар ирсэн нийт хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна.	1. Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд авто үйлчилгээ, цахим тоглоом, үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 76 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд: • Зөвшөөрсөн-42; • Магадлан шалгаж, материалын шаардлага хангуулах-24 байна. 2. Санхүүгийн зохицуулах хорооны license.frc.mn цахим системээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой нийт 43 хүсэлтийг хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн, иргэн болон хуулийн этгээдийг шаардлагатай мэдээллээр ханган ажилласан.	2025.01.02 - 2025.12.31	100%
3.	Арга хэмжээ 1.3. Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Хяналт, шалгалт зохион байгуулсан тоо, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	2024 онд мэргэжлийн байгууллагуудт ай хамтран 1 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, 144 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.	Мэргэжлийн байгууллагуудт ай хамтран 2-оос доошгүй хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан байна.	- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/116 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй махны үйлдвэр, махны агуулахын үйлчилгээ эрхлэгч 18 иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдалд зөвлөгөө өгч, зөрчлийг арилгуулахад хамтран ажилласан. - Авто үйлчилгээний газруудад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг сурталчлах, мэдээллээр хангах, зөрчил арилгуулах зорилгоор 15 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.	2025.01.02 - 2025.12.31	100%
4.	Арга хэмжээ 1.4. Дүүргийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид саарал ус ашиглах, дэвшилтэт техник тоног төхөөрөмж нэвтрүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Саарал ус ашигласан	2024 онд 12 авто угаалгын газар саарал усны төхөөрөмжийг нэвтрүүлсэн.	5-аас доошгүй авто угаалгын газар саарал усны хэрэглээг нэвтрүүлсэн байна.	Дүүргийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 63 иргэн, аж ахуйн нэгжийг цахим системд бүртгэж, ус ашиглалтын байдал, тоног төхөөрөмжийн хүчин чадал, саарал ус ашиглах нөхцөлийн судалгааг хийсэн.	2025.01.02 - 2025.12.31	100%

	чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	авто угаалгын газрын тоо			2025 оны байдлаар дүүргийн хэмжээнд 17 авто угаалгын газар саарал усны тоног төхөөрөмж суурилуулж, өдөр тутмын усны хэрэглээг дунджаар 50-60 хувиар бууруулсан үзүүлэлттэй байна. Саарал ус ашиглах боломж, дэвшилтэт тоног төхөөрөмжийн шийдлийн талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, уулзалтыг зохион байгуулж, уриалга хүргүүлсэн.	.	
ДЗДҮАХ-ийн зорилт 2.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.							
Зорилт 2. “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 2.1. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор дотоод болон олон улсын үзэсгэлэн худалдаанд хамруулж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 187 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч хамрагдсан	5-аас доошгүй удаагийн өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, 50-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилласан байна.	Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах зорилгоор 7 удаагийн арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 422 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж, нийлбэр дүнгээр 834.3 сая төгрөгийн борлуулалт хийхэд нь дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд: - Сар шинийн баярын үзэсгэлэн худалдаанд нийт 9 байршилд 228 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч; - “Нарны баяр”, “Ажилтай өрх аз жаргалтай гэр бүл” үзэсгэлэн худалдаанд 15 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч; - Хүүхдийн баярын үзэсгэлэн худалдаанд 29 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч; - Хичээлийн шинэ жилийн үзэсгэлэн худалдаанд 67 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч;	2025.01.02 - 2025.12.31	100%

					- "Намрын ногоон өдрүүд 2025" үзэсгэлэн худалдаанд 5 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч; - Хүнсний ногооны өргөтгөсөн худалдаанд 18 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч; - Амралтын өдрийн худалдаанд 60 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилласан.		
2	Арга хэмжээ 2.2. "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг байгуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Борлуулалтын төвийн байршил, төсвийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.	"Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг байгуулахтай холбогдуулан 8 аж ахуйн нэгжээс талбайн хэмжээ, үнийн саналыг авч, боловсруулан "Бүтээгч-Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн хурлаар танилцуулж, борлуулалтын төвийг байгуулах санхүүжилтийг 2026 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн.	2025.01.02 - 2025.12.31	100%
3	Арга хэмжээ 2.3. Өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж ажиллана.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэний тоо	-	2-оос доошгүй удаагийн сургалтыг зохион байгуулж, 40-өөс доошгүй иргэнийг хамруулсан байна.	Өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор туршлагатай үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран онол дадлага хосолсон 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 200 иргэнийг хамруулсан. Үүнд: - Сагс сүлжих сургалтад 50; - Оёмол, сүлжмэл хийх сургалтад 50; - Декор урлалын сургалтад 50; - Хүнсний ногоо нөөшлөх, хадгалах, талхны хөрөнгө бэлтгэх сургалтад 50 иргэнийг тус тус хамруулсан.	2025.01.02 - 2025.12.31	100%
ДЗДҮАХ-ийн зорилт 2.4 Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ.							
Зорилт 3. "Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах" зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 3.1.	Зохион байгуулсан	-	-	Дүүргийн хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэстэй хамтран		100%

	Дүүргийн нутаг дэвсгэр дэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудтай хамтран спорт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулна.	арга хэмжээний тоо, хамрагдсан иргэн аж ахуйн нэгжийн тоо			төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор хот нийтийн аж ахуй, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын дунд спортын 4 төрөлт тэмцээн зохион байгуулж, 55 байгууллагын 450 гаруй баг тамирчид оролцсон.	2025.01.02 - 2025.12.31	
2.	Арга хэмжээ 3.2. "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	-	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 50-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна.	"Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 4 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж, бизнесийн шинэлэг санаачилга, гарааны бизнес болон үйл ажиллагаагаа өргөжүүлж буй аж ахуйн нэгжүүдийг бодитойгоор дэмжин ажилласан бөгөөд үүний үр дүнд бизнес эрхлэгчдийн оролцоо нэмэгдэж, эдийн засгийн эргэлтэд шинэ ажлын байрууд бий болоход дэмжлэг үзүүлэн ажилласан.	2025.01.02 - 2025.12.31	100%
3.	Арга хэмжээ 3.3. Төр, хувийн хэвшлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах ажлыг зохион байгуулна.	Дэмжин ажилласан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	-	5-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж борлуулалтыг дэмжин ажиллана.	Төр, хувийн хэвшлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, холбон зуучлах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын худалдан авалтад нийт 40 гаруй үйлдвэрлэл эрхлэгчийг санал болгож ажилласан.	2025.01.02 - 2025.12.31	100%
4.	Арга хэмжээ 3.4. "НЭГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ-НЭГ БҮТЭЭЛЧ АЖИЛ" арга хэмжээг зохион байгуулж, авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн гадна орчин, хаягийн байгууламжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, үнэ тарифыг үйлчлүүлэгчид ил тод байлгах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 50-аас доошгүй авто үйлчилгээ эрхлэгч хамрагдсан байна.	Авто үйлчилгээ болон мөнгөн зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 52 иргэн, аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлж, хаяг хаяг, хаягийн байгууламж, хог хаягдал, гадна өнгө үзэмжийг сайжруулах ажлыг зохион байгуулсан. Үүнд: - Хаяг, хаягийн байгууламжийг сайжруулсан - 13 иргэн, аж ахуйн нэгж; - Гадна өнгө үзэмж, тохижилтын ажил хийсэн – 9 иргэн, аж ахуйн нэгж; - Үүсмэл хог хаягдлыг зайлуулсан 8 иргэн, аж ахуйн нэгж;	2025.01.02 - 2025.12.31	100%

					- Ус хэмнэх тоног төхөөрөмж суурилуулсан – 17 иргэн, аж ахуйн нэгж; - Байгууллагын орчимд ногоон байгууламж нэмсэн – 5 иргэн, аж ахуйн нэгж тус тус байна.		
Зорилт 4. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд							
1	Арга хэмжээ 4.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг чанд мөрдөн ажиллах, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг эмхлэн цэгцэлж, архивлах	Хэрэгжилтийн хувь	-	100%	2024 оны баримтыг стандарт, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу бэлтгэн 2 хадгаламжийн нэгж үүсгэж хуваарийн дагуу байгууллагын архивад хүлээлгэн өгсөн. Ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж үүсгэхээр хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.	2025.01.02 - 2025.12.31	100%
2	Арга хэмжээ 4.2. ERP, EDoc системд албан бичиг, өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	ERP, EDoc системд 13 албан бичиг, иргэний гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. 3	100%	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн erp.ulaanbaatar.mn системийн үйл ажиллагааг албан хэрэгцээндээ хэрэгжүүлж ажилласан бөгөөд тайлант хугацаанд: - Дээд газар болон бусад байгууллагаас ирүүлсэн 133 албан бичгийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. - Дээд газар болон бусад байгууллагууд руу 47 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. - Иргэдээс ирсэн 34 өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэн ажилласан.	2025.01.02 - 2025.12.31	100%
3	Арга хэмжээ 4.3. Дээд газар, байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцоно.	Оролцсон арга хэмжээний тоо	-	2	- Байгууллагаас зохион байгуулсан спортын арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцсон. - Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан бүх нийтээр мод тарих арга хэмжээнд оролцсон.	2025.01.02 - 2025.12.31	100%

					- "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон.		
4	Арга хэмжээ 4.4. Хариуцсан ажлын чиглэлээр хэрэгцээний судалгааг гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх, дээд шатны байгууллагыг мэдээллээр хангана.	Судалгааны тоо	-	3	Хариуцсан ажлын чиглэлээр бодит хэрэгцээ, нөхцөл байдлыг тодорхойлох, дээд шатны байгууллагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах зорилгоор дараах судалгааг боловсруулж, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан. Үүнд: - Авто үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа - Хүнд, хөнгөн үйлдвэрийн судалгаа - Хүнсний үйлдвэрийн судалгаа - Цахим тоглоомын газрын судалгаа - Автын хог хаягдлын судалгааг шинэчлэн, баяжилт хийсэн.	2025.01.02 - 2025.12.31	100%
5	Арга хэмжээ 4.5. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ баримт бичгийн 2.8.2-т харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлна.	Зөрчилгүй ажилласан эсэх	-	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан зөрчилгүй ажилласан байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн, сахилга бат, хариуцлагатайгаар ажиллаж, ёс зүйн зөрчилгүй ажилласан.	2025.01.02 - 2025.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
-----	----------------------------------	---------------------	-----------------	-----------------	-------------------------	--------------------------------	------------------------

1.	Нөөцийн махны нийлүүлэлт, хадгалалт, борлуулалтын хэвийн үйл ажиллагааг зохион байгуулах	-	-	-	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/08 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын "Нөөцийн махны нийлүүлэлт, хадгалалт, борлуулалтын хэвийн үйл ажиллагааг зохион байгуулах" удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн махны жижиглэн худалдааг 56 хүнсний дэлгүүр, өргөтгөсөн худалдааг 15 цэгт зохион байгуулж, махны борлуулалт, чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан.	2025.02.05 - 2025.05.30	100%
2	Зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах.	-	-	-	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2025 оны А/202 дугаар захирамжийн хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд 318 түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан.	2025.02.14 - 2025.05.30	100%
3	Дүүргийн салбар архив болон байгууллагын архивын баримтад тооллого явуулах	-	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны "Дүүргийн салбар архив болон байгууллагын архивын баримтад тооллого явуулах тухай" А/41 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд түр болон байнга хадгалах нийт 1435 баримтад тооллого хийж ажилласан.	2025.03.29 - 2025.05.10	100%
4	Цэргийн албаны ээлжит татлагын ажлыг зохион байгуулах	-	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны "Цэргийн албаны ээлжит татлагын ажлыг зохион байгуулах тухай" А/205 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/44 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хэсэгт анкет бүртгэх, хүлээн авах чиг үүргийг хариуцан ажилласан.	2025.05.02 - 2025.05.04	100%
5	Туул гол дагуу үйл ажиллагаа явуулж буй явуулын түргэн хоолны газруудад хяналт шалгалт хийж, шаардлага хангахгүй иргэн, аж ахуйн нэгжүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	-	-	-	Туул гол дагуу үйл ажиллагаа явуулж буй түргэн хоолны газруудад Нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Замын цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын явцад эрүүл ахуйн шаардлага хангаагүй, замын хөдөлгөөнд саад учруулж байсан нийт 16 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан.	2025.05.01 - 2025.11.01	100%

6	Арга хэмжээ 2.2. "Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч, магадлан шалгаж, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэнд гэрчилгээ олгох, бүртгэх ажлыг зохион байгуулна.	Ирсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	2 удаагийн хурал зохион байгуулж, 31 хүсэлтийг 100% шийдвэрлэсэн.	100%	Дүүргийн Засаг даргын 2025 оны А/317 дугаар захирамжаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, иргэдийг бүртгэх, гэрчилгээ олгох үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 11 удаа зохион байгуулж, мөнгөн зээлийн зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн 42 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн. Үүнд: - Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдээр бүртгүүлэх- 15; - Хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийн бүртгэл-14 - Салбар бүртгүүлэх-7 - Гүйцэтгэх удирдлага, хаяг, байршлын өөрчлөлт-6 иргэн, хуулийн этгээдийн бүртгэл хийгдсэн байна.	2025.07.01 - 2025.12.31	100%
7	Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хэсэгчилсэн хяналт шалгалт зохион байгуулах	-	-	-	Дүүргийн менежерийн баталсан удирдамжийн хүрээнд 15 хорооны нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 21 иргэн, аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт зохион байгуулсан. Хяналт шалгалтаар нийт 50 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, газар дээр нь 16 зөрчлийг арилгуулан ажилласан.	2025.07.07 - 2025.07.10	100%
8	Нийслэлийн "Иргэдийн баяр-хүрээ цам даншиг" наадам, Үндэсний их баяр наадам, хурдан морины 2025 оны шигшмэл "Их хурд-10" уралдааны үеэр худалдаа үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавьж ажиллах	-	-	-	Нийслэлийн "Иргэдийн баяр-хүрээ цам даншиг" наадам, Үндэсний их баяр наадам, хурдан морины 2025 оны шигшмэл "Их хурд-10" уралдааны үеэр худалдаа үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг батлагдсан байршилд байршуулах, тавигдах шаардлагын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, хяналт тавьж ажилласан. Мөн баяр наадмын үеэр зөвшөөрөлгүй ил задгай худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авч ажилласан.	2025.06.18 - 2025.08.10	100%
9	Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулж, эрчимжүүлэх	-	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны "Мал аж ахуй эрхлэх хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай" 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1024 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд	2025.10.27 - 2025.12.31	100%

					дүүргийн мал аж ахуйн хориглосон бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулж, 114 толгой адуу гаргаж, түр хадгалах хашаанд 53 толгой адууг хашаалсан. Илэрсэн зөрчилд арга хэмжээ тооцуулж, 7 хоног тутам эргүүл хийж, тогтмол хяналт тавьж ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо Суралцсан кредит цаг	-	2	- Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдаж, сертификат авсан. - Төрийн албаны зөвлөлийн "7:4:10" цахим сургалтад 2 удаа хамрагдсан.	2025.01.17 - 2025.12.31	100%
2.	Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж эсхүл бие даан суралцаж эзэмшинэ.	Хамрагдсан сургалтын тоо	-	1	- Дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад тухай бүр хамрагдсан. - Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан монгол бичгийн сургалтад хамрагдсан. - Дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Сэтгэл зүйн эрүүл мэнд" сэдэвт сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хамрагдсан. - Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгээс зохион байгуулсан "Иргэн бүр аврагч байя" сэдэвт эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга зүйн сургалтад хамрагдсан. - Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Албан хэрэг хөтлөлт болон EDOC системийн хэрэглээний талаарх сургалт"-д 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр хамрагдсан.	2025.01.02 - 2025.12.31	100%

					- "ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо, ажилтан бүрийн оролцоо" сэдэвт сургалт 2025.11.13-ны өдөр хамрагдсан.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИ, АВТО
ЗАСВАР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

И.ХУЛАН /  /
(Нэр, гарын үсэг)

2025 оны 12 дугаар сарын 01
(Огноо)

ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИ, АВТО ЗАСВАР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ИВАНЫ ХУЛАНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР
ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “ҮЙЛДВЭРЛЭЛ, АВТО ЗАСВАРТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХАНГУУЛАХ” ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД					
1.	Арга хэмжээ 1.1	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2.	59	10	69	
3.	Арга хэмжээ 1.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 1.4.	60	9	69	
Зорилт 2. “ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД					
5.	Арга хэмжээ 2.1.	60	10	70	
6.	Арга хэмжээ 2.2.	55	9	64	
7.	Арга хэмжээ 2.3.	60	10	70	
Зорилт 3. “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах” зорилтын хүрээнд					
8.	Арга хэмжээ 3.1.	57	9	66	
9.	Арга хэмжээ 3.2.	60	10	70	
10.	Арга хэмжээ 3.3.	59	10	69	
11.	Арга хэмжээ 3.4.	60	10	70	
Зорилт 3. “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”					
12.	Арга хэмжээ 4.1.	59	9	68	
13.	Арга хэмжээ 4.2.	60	10	70	
14.	Арга хэмжээ 4.3.	60	10	70	
15.	Арга хэмжээ 4.4.	60	10	70	
16.	Арга хэмжээ 4.5.	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт					
17.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	55	10	65	
18.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	60	10	70	
19.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	60	10	70	
20.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.	60	10	70	
21.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.	60	10	70	

22.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.	60	10	70	
23.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7.	59	10	69	
24.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8.	60	10	70	
25.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9.	60	10	70	
Дундаж оноо:				69,15	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.	93.37.	14	
2.	Арга хэмжээ 2.			
Дундаж оноо			14	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		6,8	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	7,5
3.	Харилцаа	8
Дундаж оноо		7,83

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 69,1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 14

3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6,8
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 7,83
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо) 93
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97,77

Үнэлгээ өгсөн:

Хүнс, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

/Л.Саруултуяа/
(албан хаагчийн нэр)
2025.12.05 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Үйлдвэрлэл, инноваци, авто засвар
хариуцсан мэргэжилтэн

.....
/И.Хулан/
2025.12.05 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....
/О.Мөнгөншагай/
2025.12.15 (огноо)


Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөц, ёс зүй хариуцсан
мэргэжилтэн

.....
/Б.Саранцацрал/
2025.12.15 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Хан-Уул дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



/З.Буянт/
2025.12.15 (огноо)